



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 25/94

Улаанбаатар хот

Хуулийн этгээдийн дүрэм шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчит “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Шинэчилэн батлагдсан дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн хороо (Б.Сэмжидмаа)-нд даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 65 дугаар тогтоол, 2021 оны 214 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.БАЯР

1725010063

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
25/94.... дүгээр тогтоолын хавсралт

“УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ” ХК-ИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

2025.04.29

9008001001

1.1. "Улаанбаатар спорт менежмент" ХК (цаашид "компани" гэх) нь Монгол Улсын Үндсэн хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гарсан бусад хууль тогтоомжийг үндэслэн байгуулсан, нийслэлийн өмчит, хаалттай хувьцаат компани байна.

1.2. Энэхүү дүрэм нь компанийн эрх зүйн байдал, зорилго, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилтийн эх үүсвэр, өмчлөл, удирдлага, хяналт, ашиг хуваарилалт болон бусад зохицуулалтыг хуульд нийцүүлэн тодорхойлсон үндсэн баримт бичиг болно.

1.3. Компанийн зорилго: Нийтийн эрүүл мэнд, биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх олон улсын жишигт нийцсэн цогцолбор байгуулж, спорт менежментийн манлайлагч хамт олон байна.

1.4. Компанийн үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

1.4.1. улс, нийслэлийн болон орон нутгийн төсвөөс хуваарилагдсан хөрөнгө оруулалт;

1.4.2. үйлчилгээ болон үндсэн үйл ажиллагаанаас олох орлого;

1.4.3. спортын уралдаан тэмцээн, бусад зохион байгуулалтын төлбөр;

1.4.4. байгууламж, талбай, техник хэрэгслийн түрээсийн орлого;

1.4.5. стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалт;

1.4.6. хөрөнгө оруулалт татах, үнэт цаас гаргах замаар бүрдүүлсэн эх үүсвэр;

1.4.7. гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс татах хандив, түншлэл, санхүүжилт;

1.4.8. олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, төсөлт дэмжлэг;

1.4.9. хувийн хэвшлийн түншлэл, КСО (нийгмийн хариуцлагын) санхүүжилт;

1.4.10. бусад хуульд нийцсэн орлого, санхүүгийн эх үүсвэр.

1.5. Компанийн оноосон нэр:

1.5.1. монголоор: "Улаанбаатар спорт менежмент" ХК;

1.5.2. англиар: "Ulaanbaatar sport management" гэж нэрлэнэ.

1.6.Компани нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өөрийн нэр, тэмдэг, логотой байна. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хэвлэмэл хуудас, тамга, санхүүгийн тэмдэг хэрэглэнэ.

1.7.Компани нь үйл ажиллагаандаа хууль ёсны зарчим, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, компанийн засаглалын үндэсний болон олон улсын сайн туршлагыг баримтална.

Хоёр. Компанийн эрх зүйн байдал

2.1.Компани нь хуулийн этгээдийн эрх зүйн чадамжтай, өөрийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх, өмч эзэмших, эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх, арбитрын байгууллагад нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох бүрэн эрхтэй байна.

2.2.Компани нь бие даасан хөрөнгөтэй, өөрийн нэр дээр данстай, бие даасан баланс, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

2.3.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

2.4.Компани нь нийслэлийн өмчийн оролцоотой хаалттай хувьцаат компани хэлбэртэй бөгөөд компанийн хувьцаа нь үнэт цаасны зах зээлд чөлөөтэй арилжаалагдахгүй.

Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1.Компани нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

3.1.1.спортын үйл ажиллагаанд менежмент хийж олон нийтийн оролцоог хангасан, бизнесийн болон нийгмийн үнэ цэнэтэй салбар болох;

3.1.2.олон улсын жишигт нийцсэн спорт цогцолбортой болох, барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.1.3.олон улсын спортын байгууллагуудтай хамтын ажиллагаа, түншлэл бий болгох;

3.1.4.хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтод бүлгийн иргэдийн спортын үйл ажиллагааг дэмжих.

3.2.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн, хугацаа хязгаарлахгүйгээр үйл ажиллагаа явуулна.

3.3.Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь холбогдох олон улсын болон үндэсний стандартад нийцсэн байна.

Дөрөв. Хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө

4.1.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бөгөөд компанийн хувьцаа нь нийслэлийн өмчид хамаарна.

4.2.Компанийн нийт зарласан энгийн хувьцаа нь 500,000 (таван зуун мянга) ширхэг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 38,251.40 (гучин найман мянга хоёр зуун тавин нэг төгрөг, дөчин мөнгө) төгрөг байна.

4.3.Хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг Компанийн тухай хууль, холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэнэ.

4.4.Компани нь хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр гаргахгүй бөгөөд хувьцаатай холбоотой аливаа хэлцлийг хууль тогтоомж, дүрмийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурал

5.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд энэ нь ээлжит болон ээлжит бус хэлбэрээр хуралдана.

5.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш гурван сарын дотор буюу жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор хуралдуулна. Хурлын тов, хэлэлцэх асуудал, холбогдох тайлан, мэдээлэл, гарах шийдвэрийн төсөл зэргийг хурал болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.

5.3.Ээлжит хурлаар компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт болон үйл ажиллагааны тайланг заавал хэлэлцэнэ.

5.4.Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

5.4.1.төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 50-иас дээш хувь нь үүргээ биелүүлэх боломжгүй болсон;

5.4.2.төлөөлөн удирдах зөвлөлийн 2 ба түүнээс дээш гишүүн, аудитын хороо, дотоод аудитын алба, эсхүл саналын эрхийн 10-аас доошгүй хувийг хэрэгжүүлэгч этгээд шаардсан;

5.4.3.компанийн алдагдал тухайн тайлант хугацаанд өөрийн хөрөнгийн 30 хувиас давсан;

5.4.4.хоёр жил дараалан компанийн өр өөрийн хөрөнгөөс давсан буюу өөрийн хөрөнгө хасах утгатай болсон.

5.5. Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.5.1.дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах;

5.5.2.компанийн хэлбэр өөрчлөх, нэгтгэх, хуваах, татан буулгах;

5.5.3.хувьцаа, үнэт цаас, бонд шинээр гаргах;

5.5.4.компанийн өрийг хувьцаагаар солих;

5.5.5.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;

5.5.6.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшуулал үйл ажиллагааны зардлын хэмжээг тогтоох;

5.5.7.санхүүгийн тайлан болон төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг батлах;

5.5.8.төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэж чадаагүй том дүнтэй болон сонирхлын зөрчилтэй хэлцэл;

5.5.9. Хувьцаа эзэмшигчээс гаргасан бусад асуудал.

Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөл

6.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагаанд ерөнхий удирдлага, хяналт тавих, хувьцаа эзэмшигчдийн хурлын хооронд тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд ажиллах хуулийн этгээдийн хамтын удирдлагын байгууллага байна.

6.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) гишүүнтэй байна. Үүнээс 6 (зургаа) нь нийслэлийн өмчийн төлөөлөл бүхий гишүүд, 3 (гурав) нь хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцсэн, тухайн компанитай ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус этгээд байна.

6.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна. Хугацаа дууссан ч шинэ гишүүдийг сонгогдох хүртэл үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

6.4.Төлөөлөн удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.4.1.компанийн стратеги, үйл ажиллагааны ерөнхий бодлого, төлөвлөгөө, төсөв батлах;

6.4.2.гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх, тэдэнтэй байгуулсан гэрээг батлах;

6.4.3.компанийн дотоод хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжилтэд хяналт тавих;

6.4.4.аудитын байгууллагыг сонгох, тайланг хэлэлцэх;

6.4.5.санхүүгийн тайланг урьдчилан хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

6.4.6.компанийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;

6.4.7.компанийн хөрөнгө, эрх бүхий хэлцлийн хязгаар тогтоох, зөвшөөрөл олгох;

6.4.8.хууль, дүрэмд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

6.5.Төлөөлөн удирдах зөвлөл нь улирал бүр хуралдана. Хуралдаанд гишүүдийн олонх нь оролцсон тохиолдолд хүчин төгөлдөрт тооцож, оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

Долоо. Гүйцэтгэх удирдлага

7.1.Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал гүйцэтгэнэ. Гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөл томилж, түүнийг чөлөөлөх, түүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээний нөхцөлийг батлах эрхтэй.

7.2.Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, эрх үүргийг тогтоосон байна. Түүнд олгох урамшууллыг бусад ижил түвшний байгууллагын жишигт нийцүүлэн хувьцаа эзэмшигч эсхүл төлөөлөн удирдах зөвлөл тогтоож болно.

7.3.Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль, энэ дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хүрээнд дараах бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.3.1.компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

7.3.2.компанийн бизнес төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэлийг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах;

7.3.3.төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, тэдэнд тайлагнах;

7.3.4.хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудыг сонгон шалгаруулах, ажлын байрны тодорхойлолтыг батлах, удирдан зохион байгуулах;

7.3.5.санхүүгийн сахилга батыг хангах, тайлан тооцоог үнэн зөв гаргах;

7.3.6.компанийн нийгмийн хариуцлага, ил тод байдлын бодлогыг хэрэгжүүлэх;

7.3.7.компанийг хууль ёсоор төлөөлөх, гэрээ хэлцэл байгуулах;

7.3.8.хууль, дүрмээр олгогдсон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

7.4.Гүйцэтгэх захирал нь хууль, дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөрчсөн, өөрийн үүргийг биелүүлээгүй, ашиг сонирхлын зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Хууль, дүрэм зөрчиж хийсэн гэрээг цуцалж, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

7.5.Гүйцэтгэх захирал дараах шаардлагыг хангасан байна.

7.5.1.дээд боловсролтой байх;

7.5.2.бизнесийн удирдлага, санхүү, эрх зүй, төрийн байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай байх;

7.5.3.компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасан хязгаарлалтад нийцсэн байх;

7.5.4.компанитай ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус байх;

7.5.5.шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр гэм буруутайд тооцогдоогүй, ёс зүйн зөрчилгүй байх.

Найм. Хариуцлага

8.1.Компанийн эрх бүхий албан тушаалтанд дор дурдсан албан тушаалтнуудыг хамааруулна:

8.1.1.төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга;

8.1.2.компанийн гүйцэтгэх захирал;

8.1.3.ерөнхий менежер

8.1.4.компанийн ерөнхий нягтлан бодогч;

8.1.5.алба, нэгжийн удирдлага;

8.1.6.компанийн зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх бүхий этгээдээр томилсон бусад албан тушаалтан.

8.2.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн санаатай, шууд буруутай үйл ажиллагаа, хайнга, хайхрамжгүй байдлаас компанид хохирол учруулсан тохиолдолд учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн нөхөн төлөх хариуцлага хүлээнэ.

8.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон нарийн бичгийн даргаас бусад эрх бүхий албан тушаалтанд тавих шаардлага, чиг үүргийг тэдгээртэй байгуулах хөдөлмөрийн болон контракт гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгана.

8.4.Компанийн удирдах албан тушаалтнууд нь хууль, дүрэм, компанийн дотоод журам, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох зохицуулалтыг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

8.5.Хариуцлагын асуудлыг Компанийн тухай хууль, Иргэний хууль болон компанийн дотоод журмын хүрээнд төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэж, шийдвэр гаргана.

Ес. Ажиллах хүчин

9.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын ангилал, нийт цалин хөлсний санг төсөвт тусган батална.

9.2.Гүйцэтгэх захирал нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бүтэц, төсвийн хүрээнд ажилтнуудыг сонгон шалгаруулж, хөдөлмөрийн болон контракт гэрээ байгуулан ажиллуулна.

9.3.Гүйцэтгэх захирал нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой дотоод журам, хариуцлагын механизм, сахилгын бодлогыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон энэ дүрэмд нийцүүлэн боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан мөрдүүлнэ.

9.4.Компани нь ажилтанд олгох цалин, урамшуулал, нэмэгдэл болон бусад хөлснөөс холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, шимтгэлийг суутган тайлагнаж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгана.

9.5.Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвөөс давсан нэмэлт орон тоо бий болгох, өндөр ур чадвар шаардсан ажилтныг ажиллуулах тухай асуудлыг Гүйцэтгэх захирал төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Арав. Ашиг хуваарилах журам

10.1.Компанийн хуримтлагдсан ашгийг үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжлийн төсөл хэрэгжүүлэх, судалгаа хийх, ТЭЗҮ боловсруулах болон нийслэлийн төсөвт ногдол ашиг хэлбэрээр шилжүүлэх зэрэг зорилгоор ашиглана. Ашиг хуваарилах бодлогыг “Ногдол ашгийн бодлого”-д тусган, хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална.

10.2.Цэвэр ашгийг хэрхэн зарцуулах талаар төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас өмнө хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүний үндэслэл, тооцоо, төсөв болон төлөвлөгөөг хуралд танилцуулна.

10.3.Хөгжлийн зорилгоор компанийн ногдол ашгаас сан бүрдүүлж болох бөгөөд уг сангийн зорилго нь үйл ажиллагаа өргөжүүлэх, төсөл хэрэгжүүлэхэд чиглэнэ.

10.4.Хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

Арван нэг. Тайлан, мэдээлэл

11.1.Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор дараах тайлан мэдээллийг боловсруулж, холбогдох этгээдэд хүргүүлнэ:

11.1.1.энэ дүрмийн 5.3-т заасан мэдээллийг компанийн цахим хуудсанд байршуулж, нийтийн хүртээл болгох;

11.1.2.дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөрөнгийн төсвийг санхүүгийн жил эхлэхээс өмнө төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

11.1.3.санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд хяналт тавих боломжийг хувьцаа эзэмшигч, дотоод болон хөндлөнгийн аудитууд, төлөөлөн удирдах зөвлөлд хангах;

11.1.4.хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл шаардсан тохиолдолд компанийн менежмент, санхүүгийн мэдээллээр хангах;

11.1.5.үндсэн үйл ажиллагааны явц, өөрчлөлт, үр дүнг жилийн тайланд тусгах;

11.1.5.албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлыг тайланд тусгах;

Арван хоёр. Санхүү, эдийн засгийн хяналт

12.1.Компанийн дотоод хяналтыг төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо хэрэгжүүлнэ. Үүнтэй холбоотой дүрэм, журмыг төлөөлөн удирдах зөвлөл баталж мөрдүүлнэ.

12.2.Компани нь СТОУС-д нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан гаргах үүрэгтэй бөгөөд гүйцэтгэх захирал нь тайлангийн үнэн зөв байдалд, ерөнхий нягтлан бодогч нь СТОУС-д нийцсэн байдалд тус тус хариуцлага хүлээнэ.

12.3.Жилийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх бөгөөд үүнийг гэрээний үндсэн дээр аудитын байгууллагаар гүйцэтгүүлнэ.

12.4.Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх, хэрэгжүүлж буй төслүүдэд гүйцэтгэлийн аудит хийлгэх шаардлагыг Аудитын хороо гаргаж, аудитын байгууллагыг сонгоно.

12.5.Компанийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

12.6.Аудит, татвар, санхүүгийн хяналт шалгалтын үед шаардлагатай баримт бичиг, ажлын байр, техник хэрэгслээр хангах үүргийг гүйцэтгэх захирал хүлээнэ.

12.7.Компани нь хууль тогтоомжийн дагуу бүх төрлийн татвар, шимтгэл, хураамжийг төлнө.

12.8.Нягтлан бодох бүртгэлийг төгрөгөөр хөтлөх бөгөөд валютын хөрөнгийг Монгол банкны ханшаар хөрвүүлэн бүртгэнэ.

Арван гурав. Бусад зохицуулалт

13.1.Энэхүү дүрэм нь компанийн үндсэн баримт бичиг бөгөөд Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

13.2.Дүрэмд тусгагдаагүй харилцааг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна.